



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар СХШ-2025/  
125

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Орхон бүсийн сум  
дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд  
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн СХШ-2025/05/ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Орхон бүсийн сум дундын ойн ангийн санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т.Мөнхзул ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 11 дүгээр сарын 17-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Орхон бүсийн сум дунд ойн ангийн 2024 он, 2025 оны 3-р дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Орхон бүсийн сум дундын ойн ангийн нь улсын бүртгэлийн 3746356 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131113002 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100131113401 дугаартай дансуудыг ашиглаж байна.

1.5 Тус газрын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Орхон бүсийн сум дундын ойн ангийн дарга Э.Сувдаа 2-р гарын үсгийг нягтлан бодогч А. Баярмаа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 15 өдрийн А/66 тоот захирамж 8 хүний орон тоо батлагдсанаас одоогийн байдлаар байгууллага нь дарга 1 ойн инженер 1, техникч 1, техникч нярав 1, нягтлан бодогч 1 гэсэн 5 оронтой ажилласан байна.

4325011073

1.7 Орхон бүсийн сум дундын ойн анги нь нь Монгол Улсын Ойн тухай хуулийн дагуу ойн нөөц, баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ойн аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны чиглэлээр байгуулагдсан байна .

Сэлэнгэ аймгийн Орхоны бүсийн сум дундын ойн анги нь Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 126-р тогтоолын дагуу 2013 оны 07-р сарын 01-ны өдөр үүссэн байгуулагдсан.

Орхоны бүсийн сум дундын ойн анги нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төвд байрладаг, Сант, Сайхан, Орхон, Орхонтуул, Хушаат, Баруунбүрэн эдгээр 6 сумд, Номгон, Рашаант тосгодыг хамарсан нийт 474,900 /мянган га/ талбай газартай ,үүнээс ойн сангийн газар 96,533 га талбай эзэлж байна.

**Байгууллагын эрхэм зорилго:** Ойн санг хамгаалах, зүй зохистой ашиглах, ойн баялгийн нөөцийг тодорхойлох, үржүүлэх, нөхөн сэргээх, түймрээс хамгаалах, ойн дагалт баялгийг зүй зохистой ашиглах хамгаалах үйл ажиллагааг эрхэм зорилго болгон ажиллаж байна.

2024 онд боловсон хүчин чадавхжуулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх, нөхөрлөлүүдийг чадваржуулах чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан бөгөөд 2025 оноос Сэлэнгэ аймгийн "Зүүнхараа" Политехник коллежийн дипломын боловсрол олгох 1.5 жилийн сургалтад "Ойн техникч" бэлтгэх хосолсон сургалтад Баруунбүрэн сумын нийт 17 суралцагчийг бүртгүүлж, тус окутнуудын суралцах орчин, практик нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээж гуравласан гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Тус байгууллага нь ойн чиглэлийн мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэхээс гадна иргэдийн ойг хамгаалах, нөхөн сэргээх үржүүлэх, зөв зохистой ашиглах, мөн ойн тухай, байгаль орчны тухай хуулийн мэдлэгийг дээшлүүлэхэд зорьж ажилласан байна .2024 онд Орхоны бүсийн сум дундын ойн анги нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/450 дугаар тушаалаар батлагдсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах журам"-ын 2.1 дэх заалтыг үндэслэн 2024 онд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх хуш модны самрын нөөцийг тогтоохоор Баруунбүрэн сумын ашиглалтын бүс-Тарвагатай, Хүж, Зүүвч, Бумбат Сэндэн гэх газрын ойн санд Ойн газрын даргын 2023 оны 08 сарын 17-ны өдрийн А/178 дугаар тушаалаар баталсан. "Сибирь хушны самрын ургац тодорхойлох аргачлал" ашиглан тооллого, хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Нөөц тогтоосон байдал сумын ашиглалтын бүсэд нийт 6-н цэг 10 модноос дээж авч тооллого хийхэд Ашиглалтын бүсэд: 1 модноос дунджаар 73,5 ширхэг боргоцой, боргоцойны өндөр 5-9 см, өргөн нь 4-6 см, 1 боргоцойноос 69-102 ширхэг дунджаар 72,8 ширхэг үр гарч байна. 1000 үрийн жин 209грамм (0,209кг), 1га талбайн үрийн модны тоо 61.5 ширхэг. Ургацын байдал: Ойн дунд хэсэгт болц гүйцэж яваа насны модонд боргоцой сайн, (титмийн 3/5-аас дээш), ойн захад болон ургасан болон дундаж насны ойд ( титмийн оройд 1/5 хэсэгт) харьцангуй бага

боргоцойтой байна. Мөн 6-15 метрийн өндөртэй зулзаган модонд 2-10ш боргоцой буюу залуу зулзаган мод их үрлэсэн байна.

Орхоны бүсийн сум дундын Ойн анги нь **Ойн хөнөөлт шавжийн** судалгааны ажлыг үндэслэж тус Байгаль орчны газар, болон Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3500 га талбайд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, "Ойн таксац" ХХК нь Сибирийн хүр эрвээхэй, Бүгэг төөлүүр эрвээхэй болох ойн хөнөөлт шавжтай тэмцэх туршилт, судалгаа, тэмцлийн ажлыг Монгол орны ойн салбарт шинээр нэвтрүүлж буй дэвшилтэт технологи бүхий Ойн хөнөөлт шавжтай тэмцэх зориулалтын Аграс Т40 (DJI Agras T40) дрон, микробиологийн аргаар хийж гүйцэтгэсэн байна.

### Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

#### 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Орхоны бүсийн сум дундын ойн анги нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна

#### 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2024 онд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 114,877.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 89.4 хувь буюу 102,742.3 мянган төгрөгийг зарцуулж, 10.6 хувь буюу 12,135.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 8,828.1 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 1,117.8 мянган төгрөгийн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,600.2 мянган төгрөгийн, томилолтын зардлаас 34.0 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 285.0 мянган төгрөгийн, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас 270.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай.

Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал: /2024 он/

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,877.7	102,742.3	12,135.3	89.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,848.2	71,020.0	8,828.1	88.9
210101	Үндсэн цалин	40,781.9	46,614.6		114.3
210102	Нэмэгдэл	29,373.3	18,429.2		62.7

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,493.0	3,130.5		57.0
210104	Урамшуулал	4,200.0	2,845.6		67.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,981.0</b>	<b>8,863.1</b>	<b>1,117.8</b>	<b>88.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,787.1	6,157.0	630.0	90.7
210202	Тэтгэмжийн даатгал	798.5	684.2	114.3	85.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,996.2	1,504.9	491.2	75.4
210204	Ажилгүйдлийн даатгал	399.2	458.0	(58.8)	114.7
210205	Эрүүл мэндийн даатгал	-	58.9	(58.9)	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,465.9</b>	<b>865.6</b>	<b>1,600.2</b>	<b>35.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	690.0	78.8	611.1	11.4
210302	Түлш, халаалт	1,676.9	786.8	890.1	46.9
210303	Цэвэр, бохир ус	99.0	-	99.0	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,913.6</b>	<b>5,913.6</b>	-	
210401	Бичиг хэрэг	110.0	110.0	-	
210402	Тээвэр, шатахуун	5,200.0	5,420.6	(220.6)	104.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	281.0	140.4	140.6	50.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	322.6	242.6	80.0	75.2
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>504.0</b>	<b>504.0</b>	-	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	504.0	504.0	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,280.0</b>	<b>10,280.0</b>	-	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,904.4	8,904.4	-	100.0
210604	Урсгал засвар	1,375.6	1,375.6	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>220.0</b>	<b>186.0</b>	<b>34.0</b>	<b>84.5</b>
210702	Дотоод албан томилолт	220.0	186.0	34.0	84.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,695.0</b>	<b>4,610.0</b>	<b>285.0</b>	<b>94.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,610.0	4,610.0	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	100.0	-	100.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70.0	-	70.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35.0	-	35.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	80.0	-	80.0	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>770.0</b>	<b>500.0</b>	<b>270.0</b>	<b>64.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>770.0</b>	<b>500.0</b>	<b>270.0</b>	<b>64.9</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	770.0	500.0	270.0	64.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>114,877.7</b>	<b>102,742.3</b>	<b>12,135.3</b>	<b>89.4</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>94,877.7</b>	<b>68,700.5</b>	<b>26,177.1</b>	<b>72.4</b>
320001	Орон нутгийн төсвөөс	94,877.7	68,700.5	26,177.1	72.4
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>20,000.0</b>	<b>34,041.8</b>	<b>(14,041.8)</b>	<b>170.2</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.0	34,041.8	(14,041.8)	170.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,302.1	1,302.1	-	
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>5.0</b>	<b>5.0</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.0	4.0	-	100.0

2025 онд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2025 оны 3-р дугаар улирлын байдлаар 145,499.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 65.7хувь буюу 95,639.8. мянган төгрөгийг зарцуулж, 34.3 хувь буюу 49,859.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 41,909.3 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 5,725.42 мянган төгрөгийн , байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 988.7 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 760.4 мянган төгрөгийн ,хангамж бараа материалын зардлаас 50.31 мянган төгрөгийн, томилолт зардлаас 425.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал: /2025 он/

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт хэмнэлт	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>145,499.0</b>	<b>95,639.8</b>	<b>49,859.1</b>	<b>65.7</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>114,726.2</b>	<b>72,815.8</b>	<b>41,909.3</b>	<b>63.5</b>
210101	Үндсэн цалин	51,775.2	53,859.6	(2,084.4)	104.0
210102	Нэмэгдэл	62,950.0	18,956.1	43,993.8	30.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>14,838.0</b>	<b>9,112.5</b>	<b>5,725.4</b>	<b>61.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,841.2	6,196.5	3,644.7	63.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,168.6	729.0	439.5	62.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,020.7	458.0	562.6	44.9
210204	Ажилгүйдлийн даатгал	255.7	270.9	(15.2)	106.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,551.8	1,458.0	1,093.7	
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,166.2</b>	<b>177.4</b>	<b>988.7</b>	<b>15.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	612.2		612.2	-
210302	Түлш, халаалт	554.0	177.4	376.5	32.0
210303	Цэвэр, бохир ус			-	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,845.1</b>	<b>5,823.6</b>	<b>21.5</b>	<b>99.6</b>
210401	Бичиг хэрэг	1,267.1	950.1	317.0	75.0
210402	Тээвэр, шатахуун	2,100.0	2,456.3	(356.3)	117.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600.0	550.0	50.0	91.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,878.0	1,838.3	39.6	97.9
2105	<b>Нормативт зардал</b>	<b>3,184.0</b>	<b>3,184.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,184.0	3,184.0	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,726.0</b>	<b>3,726.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	3,726.0	3,726.0	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,125.0</b>	<b>700.0</b>	<b>425.0</b>	<b>62.2</b>
210702	Дотоод албан томилолт	1,125.0	700.0	425.0	62.2

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	889.5	129.1	760.3	14.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108.0		108.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	214.2		214.2	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179.4	129.1	50.2	72.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	63.9		63.9	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	324.0		324.0	-
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>145,499.0</b>	<b>100,573.7</b>	<b>44,925.3</b>	<b>69.1</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>125,499.0</b>	<b>71,024.1</b>	<b>54,474.9</b>	<b>56.6</b>
320001	Орон нутгийн төсвөөс	125,499.0	71,024.1	54,474.9	56.6
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>20,000.0</b>	<b>29,549.6</b>	<b>(9,549.6)</b>	<b>147.7</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.0	29,549.6		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,933.8	(4,933.8)	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,054.5	475.0	12,579.5	3.6
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>3.0</b>	<b>3.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	2.0	2.0	-	100.0
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>5.0</b>	<b>5.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.0	4.0	-	100.0

**Үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсөв гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал.**

Орхон бүсийн сум дундын ойн анги нь 2021 онд 30,95.0 мянган төгрөгийн , 2022 онд 30,745.2 мянган төгрөгийн , 2023 онд 34,730.1 мянган төгрөгийн буюу сүүлийн 3 жилийн дунджаар 32,144.7 мянган төгрөгийн, өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн байтал, 2024-2025 онуудын өөрийн орлогыг нэмэгдүүлэлгүйгээр 20,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 2024 онд төсвийн гүйцэтгэлээр 34,041.8 мянган төгрөг, 2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа 29,549.6 мянган төгрөгийг орлого төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.6 дахь "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитоор тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй", 3 дугаар зүйлийн 3.6 дахь "Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/-ын

сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон... үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### **2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт олголтын байдал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:**

Орхоны бүсийн сум дундын ойн анги нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын захирамжаар 2024 оны 02-р дугаар сарын 15 өдрийн А/66 Захирамжаар ойн ангийн 8 орон тоогоор баталсан байна.

Орхоны бүсийн сум дундын ойн ангийн даргын тушаал 2025 оны 01-р дүгээр сарын 02 өдөр Б/01 тушаалаар албан хаагчдын цалин шинэчлэн тогтоосон байна.

2024 онд албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийхэд цалингийн зардалд 79,848.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 9,981.00 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалд зардалд 71,020.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 8,863.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж цалин хөлс, нэмэгдэл урамшуулал зардлаас 8,848.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 1,117.87 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй байгаа нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна.

Орхоны бүсийн сум дундын ойн ангийн даргын тушаал 2025 оны 01-р дүгээр сарын 02 өдөр Б/01 тушаалаар албан хаагчдын цалин шинэчлэн тогтоосон байна.

2025 онд цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардал 114,725.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 14,838.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардалд 72,815.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 9,112.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж 2025 оны 3-р улирлаар жилийн байдлаар, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал зардлыг 49,859.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 5,725.42 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа нь батлагдсан орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна.

Орхоны бүсийн сум дундын ойн ангийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг, Төрийн албаны тухай хуулийн 4-р дүгээр зүйлийн 4.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 108.1 дугаар зүйлийн, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын, 2022 оны 489,491 дүгээр тогтоол, дээрх хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэн мөрдөж ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг цалингийн батлагдсан төсвөөр олгосон байна.

Цалин хөлсний тогтоолт, тооцоололтыг тулган баталгаажуулахад: Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8

тайлантай нэг-бүрчлэн тулган шалгахад илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

#### **2.4. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур хангасан эсэх**

2024 онд Ойн инженерийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан дагуу ойн инженерийн мэргэжилтэй 1 хүн бүртгүүлсэн байна., албан тушаалын тодорхойлолтод шаардлага хангасан Ойн инженерийн мэргэжилтэй, мэргэжлийн ур чадварын шалгалтыг тестээр болон ярилцлагын шалгалт авч дүгнэж албан тушаалд томилсон байна.

#### **Нэмэлт санхүүжилтийн дансанд:**

2024 онд нэмэлт санхүүжилтийн 100131113401 тоот дансанд байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 1,302.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлсэн. Үүнээс Байгаль орчин яам дансанд үнэт цаасны төлбөрийг 1,302.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь байна.

2025 оны 3-р улирлын байдлаар нэмэлт санхүүжилтийн 100131113401 тоот дансанд байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 475.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Зарлагын гүйлгээ хийдээгүй байна.

#### **2.5 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

2024, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны босго үнээс давсан худалдан авалт хийдээгүй байна

#### **2.6 Авлага, өр төлбөрийг баталгаажуулж , данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх**

Орхоны бүсийн сум дундын ойн анги нь 2024 онд шатахуун өглөг 71,7 мянган төгрөгийн өр төлбөр тооцоо нийлж баталгаажуулалт хийдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна

#### **2.7 Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал**

Орхон бүсийн сум дундын ойн ангид 2024, 2025 онуудад Төсвийн тухай хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитаас бусад төрлийн хөндлөнгийн хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна.

Тус ойн ангийн санхүүгийн тайлангийн аудит нь Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн

гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд түүвэр байдлаар хамрагдан шалгагдсан бөгөөд санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй, зөвлөмж өгөгдөөгүй болно.

## **2.8 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт Үндсэн хөрөнгө:**

Орхоны бүсийн ойн бүсийн анги нь 2024 оны эхэнд 71,243.8 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд 8,529.0 хөрөнгө худалдан авсан, бөгөөд ахуйн эд хогшил 7,070.6 мянган төгрөгийн өртөгтэй нийт 11,203.2 мянган төгрөгийн актлагдсан байна худалдан авч 68,569.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2025 оны 3 дугаар улирлын байдлаар 68,935.9 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй бай Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол 2024 оны 04-р дүгээр сарын 10 өдрийн 28-р дугаар тогтоолыг хэрэгжүүлсэн буюу машин тоног 67,500.0 мянган төгрөгийн хөрөнгийн үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд тусгасан байна. Машин тоног төхөөрөмж 32,321.4 мянган төгрөгийн актлагдсан байна. Үндсэн хөрөнгийн 103,748.2 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээ бүрэн нөхсөн 0 үлдэгдэлтэй цаашид ашиглалтын жилийн шинэчлэн тогтоож дахин үнэлж үргэлжлүүлэн ашиглах боломжтой Барилга байгууламж 9,479.3. мянган төгрөгийн үнэтэй хөрөнгүүдийг УСНББОУС-д нийцүүлэн шийдвэрлээгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна. Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийж эд хариуцагчийн картыг хөтөлж хэвшсэн байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг явцад ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалт гаргаж өмч хамгаалах зөвлөлд шилжүүлэн, акталж устгах, шилжүүлэх зэргээр холбогдох дээд газрын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж, данс бүртгэлд тусгасан байна

2024-2025 онд Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгө шинээр авч байгаа хөрөнгөд бүрэн бүтэн байдал чанарын шаардлага хангасан дээр 4 удаа хуралдсан байна. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглах боломжгүй хөрөнгийн талаар 4 удаа хуралдаж, хугацаа дууссан хөрөнгийг буюу элэгдлээрээ өртөг нөхсөн хөрөнгийг актлах саналыг хурлын шийдвэр гаргасныг байгууллагын удирдлагууд танилцуулж ажилласан байна

## **2.9. Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналт тогтолцоо төлөвшсөн эсэх.**

Орхоны бүсийн сум дундын ойн анги нь 2024–2025 онд өөрийн харьяа ойн бүсэд хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, хууль бус мод бэлтгэл, тээвэрлэлтийн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох зорилгоор Сэлэнгэ

аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон хариуцсан сумдын байгаль хамгаалагч нартай хамтран нийт 67 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт явуулсан байна.

Дээрх хяналт шалгалтын хүрээнд нийт 12 зөрчлийг илрүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажилласан болно.

### 2.10 Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлийг заавар аргачлалын дагуу бүрэн үнэн зөв хөтөлсөн эсэх

Орхоны бүсийн сум дундын ойн ангийн нь 2024-2025 оны 3-р дугаар улирлын байдлаарх санхүүгийн ажил гүйлгээг анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг тулган баталгаажуулахад худалдан авалтын И-төлбөрийн баримтаар баталгаажуулахаар 1,141.0 мянган төгрөгийн 1удаагийн ажил гүйлгээ 2025 оны 3-р дугаар улирлаар 1,108.0 мянган төгрөгийн 1удаагийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм..." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### 2.11 төсөвт төвлөрүүлэх орлогын үндэслэлтэй төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх

Орхоны бүсийн сум дундын ойн анги нь Баруунбүрэн сумын ИТХ-ын 2024 оны 10-р дугаар сарын 03-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор 2024 оны тодотгосон төсөв батлах, 2024 оны Ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг 147,222.8 мянган төгрөгөөр төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

2024 онд Ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг гүйцэтгэлээр 54,953 мянган төгрөгөөр буюу 37.3 хувьтай төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсөвт төвлөрүүлсэн орлогыг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

(мянган төгрөгөөр)

Д/Д	Сумын нэр	Хэрэглээний мод		Түлээ		Нийт м³	
		Хэмжээ м³	Төсөвт орсон орлого /төг/	Хэмжээ м³	Төсөвт орсон орлого /төг/	Хэмжээ м³	Төсөвт орсон орлого /төг/
1	Баруунбүрэн	1203.84	26,167	2851	7,995	4054.84	34,162

2	Орхон сум			650	1,832	650	1,832
3	Сайхан сум	312.24	1,835	500	1,426	812.24	3,261
4	Сант сум	68	1,846	2487	7,019	2555	8,865
5	Хушаат	150	1,188	836	4,278	986	5,466
6	Орхонтуул			485	1,367	485	1,367
	Нийт дүн	1734.08	31,037	7809	23,916	9543.8	54,953

Баруунбүрэн сумын ИТХ-ын 2025 оны тодотгосон төсөв батлах 10-р дугаар сарын 03- ний өдрийн 41 дүгээр тогтоолоор 2025 оны Ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг 84,254.4 мянган төгрөгөөр төсөв төвлөрүүлэхээр батлагдсан байна . 2025 оны 3-р улирлын байдлаараа ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг гүйцэтгэлээр 54,953 мянган төгрөгөөр буюу 37.3 хувьтай төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсөвт төвлөрүүлсэн орлогыг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

(мянган төгрөгөөр)

д/д	Сумын нэр	Хэрэглээний мод		Түлээний мод		Нийт м³	
		Хэмжээ м³	Төсөвт орсон орлого /төг/	Хэмжээ м³	Төсөвт орсон орлого /төг/	Хэмжээ м³	Төсөвт орсон орлого /төг/
1	Баруунбүрэн	413.79	3,125.0	3659	10,315.0	4072.59	13,440
2	Орхон сум			800	2,255.0	800	2,255
3	Сайхан сум			356	1,004.0	356	1,004
4	Сант сум			2830	7,978.0	2830	7,978
5	Хушаат	613.12	3,871.0	896	3,821.0	1509.12	7,693
6	Орхонтуул			46	130.0	46	130
	Нийт дүн	1026.91	6,996.0	8587	25,502.0	9613.71	32,499

**Аймгийн ИТХ-аар баталсан 2024-2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод ,түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоолын хэрэгжилт**

Баруунбүрэн сумын ИТХ-ын 2023 оны 12-р дугаар сарын 20-ны өдрийн 86 дугаар тогтоолын дагуу сумнуудад хэрэглээ болон түлээний мод бэлтгэх газрыг 2024 онд мод бэлтгэлийн талбайн тусгаарлалт 101 дүгээр талбарт нийт 158.6 га газар хэрэглээ болон түлээний зориулалттай мод бэлтгэх талбайн тусгаарлалт хийж, эхлэлийн акт болон технологийн картыг бүрдүүлэн хяналт хийж ажилласан байна. 2024 онд мод бэлтгэх хэмжээг нь хэрэглээний мод 5856 м³ түлээний мод 12137 м³ батлагдсан бөгөөд биелэлт нь хэрэглээний мод 1734.08 м³ буюу 29.6 хувьтай түлээний мод 7809 м³ буюу 64.3 хувьтай эрэгжүүлсэн байна.

Сумуудын хэрэглээ мод , түлээний мод хуваарийн хэрэгжилтийн доорх хүснэгт 4 харуулав

## Хүснэгт 4

(мянган төгрөгөөр)

№	Сумын нэр	ИТХ-аар батлагдсан бэлтгэх модны хэмжээ м³		Бэлтгэсэн модны хэмжээ м³		Үлдэгдэл модны хэмжээ м³		Хэрэгжилтийн хувь	
		Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ
1	Баруунбүрэн иргэд	3371	6313	1203.84	2851	2167.16	3462	35.7	49.8
2	Сайхан сум	545	654	312.24	500	232.76	154	57.3	100
3	Орхонтуул сум		500		485		15		97
4	Орхон		650	0	650		0		100
5	Хушаат	1485	1920	150	836	1335	1084	10.1	43.5
6	Сант	1000	3250	68	2487	932	763	6.8	76.5
	<b>дүн</b>	<b>5856</b>	<b>12137</b>	<b>1734.08</b>	<b>7809</b>	<b>5533.9</b>	<b>4611</b>	<b>29.6</b>	<b>64.3</b>

Баруунбүрэн сумын ИТХ-ын 2025 оны 03-р дугаар сарын 21-ны өдрийн 29 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод 4537м³, түлээний мод бэлтгэх 13852 м³ хэмжээтэй баталсан бөгөөд 2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа хэрэглээний мод 1026.9 м³ буюу 22.6 хувьтай, түлээний мод 8587 м³ буюу 62 хувьтай хэрэгжилттэй байна

Сумуудын хэрэглээ мод, түлээний мод хуваарийн хэрэгжилтийн доорх хүснэгт 5 харуулав

## Хүснэгт 5

(мянган төгрөгөөр)

№	Сумын нэр	ИТХ-аар батлагдсан бэлтгэх модны хэмжээ /м3/		Бэлтгэсэн модны хэмжээ /м3/		Үлдэгдэл модны хэмжээ /м3/		Хэрэгжилтийн хувь	
		Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ
1	Баруунбүрэн иргэд	1967	3952	413.79	3659	1553.21	293	21	92.6
2	Сайхан сум	375	2000	312.24	356	375	1644		17.8
3	Орхонтуул сум	449	300		46	449	254	10	15.3
4	Орхон	30	2200	0	800	30	0		36.4
5	Хушаат	1300	1600	613.12	896	686.88	1400	10.1	56
6	Сант	416	3800		2830	416	704	69	74.5
	<b>дүн</b>	<b>4537</b>	<b>13852</b>	<b>1026.9</b>	<b>8587</b>	<b>3510.09</b>	<b>5265</b>	<b>22.6</b>	<b>62</b>

**Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал,  
илэрсэн зөрчил дутагдал**

2024 он, 2025 оны 3-р дугаар улирлын төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна. Үүнд:

**Илрүүлэлт 1.** Худалдан авалтын цахим төлбөрийн баримтаар баталгаажуагүй, бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг бөөн дүнгээр 2024 онд 1,141.0

мянган төгрөгийн, 2025 онд 1,108,6 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримтыг бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь " Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авалт хийх тухай бүрд бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр орлого авч, цахим баримтаар баталгаажуулж, зарцуулалтаараа зарлагадаж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2.** Өмнөх онууд болон 2024 онд 14,041,800.0 (Арван дөрвөн сая дөчин нэгэн мянган найман зуун) төгрөгөөр, 2025 оны 3-р улирлын байдлаар 9,549,600.0 (Есөн сая таван зуун дөчин есөн мянган зургаан зуунтөгрөг)-өөр давсан атал өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэлтэй харьцуулалагүйгээр сүүлийн 3 жил орлогын төлөвлөгөөг тогтмол 20,000,000.0 (Хорин сая төгрөг)-өөр төсвийг үндэслэлгүй төлөвлөж батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.6 дахь "Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитоор тооцож төсөвт тусгуулах ба хэрэв үндэслэлгүй төлөвлөгөө батлуулсан нь нотлогдвол энэ журамд заасан зарцуулах эрх олгохгүй", 3 дугаар зүйлийн 3.6 дахь "Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/-ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон... үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

**Шийдвэрлэсэн нь:** Төлөвлөгөөнөөс давж биелсэн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэл, үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 3.** 2024 онд шатахуун өглөгийн 71.7 мянган төгрөгийн өр төлбөр тооцоо нийлж баталгаажуулагүй бүртгэл тайланд тусгасан байна.

Төсвийн тухай хуулий 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 4.** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээ бүрэн нөхсөн 0 үлдэгдэлтэй цаашид ашиглалтын жилийн шинэчлэн тогтоож дахин үнэлж үргэлжлүүлэн ашиглах боломжтой Барилга байгууламж 9,479,3. мянган төгрөгийн үнэтэй хөрөнгүүдийг УСНББОУС-д нийцүүлэн шийдвэрлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** УСНББОУС-17 заасны дагуу үндсэн хөрөнгийг цаашид үргэжлүүлэн ашигах бол ашиглалтын жилийг шинэчлэн тогтоох, актлах саналтай бол санлыг журмын дагуу аймгийн ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгөв.

### **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

#### **4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Орхоны бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

#### **4.2 Шийдвэрлэлт:**

Орхоны бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **35,752.1** мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох **26,272.8** мянган төгрөгийн 3 албан шаардлага, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх **9,479.3** мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

#### **Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:**

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Орхон бүсийн сум дундын ойн ангийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг дарга, нягтлан бодогч нарт нь хариуцуулав.

**ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:**

ДОТООД АУДИТОР

Д.ВАНЧИГМАА

**ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ *Monchzul* МӨНХЗУЛ



**ТАНИЛЦСАН:**

ОРХОН БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН  
ДАРГА

Э.СУВДАА

НЯГТЛАН БОДОГЧ

А.БАЯРМАА

